

25

**БНМАУ**  
**УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН**  
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ**

19 21 оны 03 сарын 28

№ 97

Улаанбаатар  
хот

**Өнгөт гэрэл зургийн төв**  
**байгуулах тухай**


Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргаанаас  
ТОГТООХ нь:

1.Германы "АГФА" нүүсийн иж бүрэн автомат төхөөрөмжөөр то-  
ноглогдсон Өнгөт гэрэл зургийн төвийг 1991 оны 4 дүгээр сарын  
1-нээс эхлэн байгуулж, хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргааны  
шууд харьяалалд аж ахуйн тооцоон дээр ажиллуулсугай.

2.Өнгөт гэрэл зургийн төвийн дүрмийг 1 дүгээр хавсралтаар  
баталсугай.

3.Тус төвийн зардал, төсөв, цалингийн санг хянан баталж,  
түр хугацаагаар 250,0 мянган төгрөг олгож санхүүжүүлэхийг Сан-  
хүүгийн газар /Н.Гонгор/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИР-  
ГААНЫ ДАРГА



Л. ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН  
ДАРГА



Ч. СУМААХҮҮ

*27.11.1991 Зассан  
Хүснэгт 7404*



Улаанбаатар хотын Ардын Хурлын  
гүйцэтгэх захиргааны 1991 оны  
гүйцэтгэх 83 дугаар сарын 28 ны эд-  
захиргааны 97 дугаар тогтоолын  
хавсралт

**ӨНГӨТ ГЭРЭЛ ЗУРГИЙН ТӨВИЙН  
ДҮРЭМ**

1. Өнгөт гэрэл зургийн төв нь хэмжээний гэрэл зургийн үйлчилгээг эрхэлж, дэд салбарын бодлогыг боловсруулан харагжуулах үүргийг хүлээнэ. ✓
2. Тус төв нь хөдөлмөрдийн, албан байгууллагын болон гадаадын жуулчдын захиалгаар өнгөт зураг сонирхогчдын хальсыг боловсруулах, буулгах үйлчилгээг бүрэн хариуцна. ✓
3. Өнгөт зургийн төв нь төлөвлөсөөгөө өөрөө боловсруулж батлан аж ахуйн бүрэн тооцоон дээр ажиллаж, бие даасан байгууллагын бүх эрхийг эдлэнэ. ✓
4. Өнгөт гэрэл зургийн төв нь гэрэл зургийн салбарын материаллаг баазыг бэхжүүлэх, мэргэжилтэй ажилчдыг бэлтгэх, техник тоног төхөөрөмжөөр хангах, цэг салбарыг байгуулах, өнгөтгөхөд мэргэжлийн туслалцаа үзүүлнэ. ✓
5. Өнгөт гэрэл зургийн төвийг Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны даргын захирамжаар томилогдсон дарга удирдаж байгууллагынхаа үйл ажиллагааны талаарх бүхий л асуудлыг гүйцэтгэх захиргааны өмнө хариуцна. ✓
6. Өнгөт гэрэл зургийн төв нь өөрийн баталсан үнэ тарифыг мөрдөнө. ✓
7. Аймаг, хот, районоос зураг, хальс хүлээн авах, түгээн олгоход холбогдох гарах зардлыг өнгөт гэрэл зургийн төв бүрэн хариуцна. ✓
8. Өнгөт гэрэл зургийн төв нь зохиомж, гэрэл, фокүс тохироогүй хальс боловсруулахаас татгалзах, буруутан хүнд материалын хариуцлага хүлээлгэх эрх эдлэнэ. ✓
9. Ажлын тайлан, баланс, төлөвлөгөөний биелэлтийг гүйцэтгэх захиргааны холбогдох хэлтэст тогтоосон хугацаанд нь өгч байна. ✓
10. Аймаг, хот, сум, суурин газруудаас захиалга хүлээн авч үйлчилнэ. ✓

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН  
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГАА